



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/85

Мандалговь

Газар эзэмшүүлэх тухай

Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Сайнцагаан сумын
өвсний агуулахын зүүн талд Их тойруу-5-511в)-д байршилтай 3000м.кв (0.3га)
газрыг Дундговь аймгийн хүнс, хөдөө аж ахуйн газар (РД:9033114)-т өвс
тэжээлийн агуулахын зориулалтаар 30 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн
гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-
Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг
болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

481210225